

ЭН АР СИ СИ компани Хэрэглэгчийн итгэлийн улирал тутмын судалгааг Монгол-Японы хүний нөөцийн хөгжлийн төвтэй хамтран 2024 оны эхний 3 сард амжилттай зохион байгууллаа. Судалгаанд Монгол Улсын 21 аймаг, нийслэл Улаанбаатар хотын 991 иргэд хамрагдаж, эдийн засгийн өнөөгийн төлөв, ойрын ирээдүйн хандлагын талаар мэдээлэл өгсөн байна.


Хэрэглэгчийн итгэлийн индекс

Монгол Улсын хэрэглэгчдийн эдийн засагт итгэх итгэл 2024 оны 1-р улиралд өмнөх улирлаас 11.8 пунктээр өссөн байна. Бизнесийн нөхцөл болон хөдөлмөрийн зах зээлийн өнөөгийн байдлын талаарх хэрэглэгчдийн үнэлэмжийг харуулдаг *Өнөөгийн байдлын индекс* энэ улиралд 97.6-аас 107.1 болж өссөн, хэрэглэгчдийн

бизнесийн нөхцөл, орлого болон хөдөлмөрийн зах зээлийн ойрын ирээдүйн хүлээлтийг харуулдаг *Ирээдүйн хүлээлтийн индекс* 84.8-аас 97.4 болж өсжээ. Хэрэглэгчийн итгэлийн индекс (ХИИ) 99.8 байгаа нь жилийн өмнөхөөс 17.6 пунктээр өндөр үзүүлэлт юм.

Хэрэглэгчийн Итгэлийн Индекс (2018=100)

Хэрэглэгчийн итгэл 99.8 буюу өмнөх улирлын түвшингээс 11.8 пунктээр өссөн бол жилийн өмнөхөөс 17.6 пунктээр өссөн байна. Энэ улиралд өнөөгийн байдлын үнэлэмж 9.5 пунктээр, ирээдүйн хүлээлт 12.6 пунктээр өссөн байна.



Тайлбар: ХИИ болон түүний бүрэлдэхүүн индексүүдийг улирлын нөлөөгөөр засварлаж, 2018 оны 4-р улирлын индекстэй харьцуулж тооцсон (Индекс 2018=100).

Эдийн засгийн өнөөгийн нөхцөл байдал

Хэрэглэгчдийн эдийн засгийн өнөөгийн байдлын үнэлэмж өмнөх улирлаас өсжээ. Үүнд бизнесийн нөхцөлийн талаарх үнэлэмж өссөн нөлөөлсөн. 10.9 хувь нь бизнесийн нөхцөл “сайн” гэж хариулсан нь 4.5 пунктээр өндөр байна. 46.2 хувь нь бизнесийн нөхцөл “муу” гэж хариулсан бөгөөд энэ нь 10.3 пунктээр доогуур

байна. Харин хэрэглэгчдийн хөдөлмөрийн зах зээлийн үнэлгээ буурсан. 24.9 хувь нь ажлын олдоц “элбэг” гэж хариулсан нь өмнөх улирлаас 2.7 пунктээр доогуур, 37.0 хувь нь ажил олоход “хэцүү” гэж хариулсан нь өмнөх улирлаас 1.6 пунктээр өндөр байна.

ХИИ-д нөлөөлж буй хүчин зүйлс

	2023.I	2023.IV	2024.I	Жилийн өөрчлөлт	Улирлын өөрчлөлт
Өнөөгийн байдал					
<i>Бизнесийн нөхцөл</i>					
Сайн	4.6	6.4	10.9	6.3	4.5
Хэвийн	34.0	36.2	41.7		
Муу	61.4	56.5	46.2	-15.2	-10.3
<i>Ажлын олдоц</i>					
Сайн	25.8	27.6	24.9	-0.9	-2.7
Хэвийн	31.5	35.4	35.7		
Муу	42.1	35.4	37.0	-5.1	1.6
Ойрын ирээдүй					
<i>Бизнесийн нөхцөл</i>					
Сайн	14.6	11.4	15.2	0.6	3.8
Хэвийн	51.3	58.2	61.4		
Муу	32.7	28.1	19.5	-13.2	-8.6
<i>Ажлын олдоц</i>					
Сайн	21.8	20.5	24.3	2.5	3.8
Хэвийн	57.9	60.4	54.3		
Муу	18.8	15.9	17.8	-1.0	1.9
<i>Орлого</i>					
Сайн	20.5	20.1	24.7	4.2	4.6
Хэвийн	62.2	63.9	58.3		
Муу	16.7	14.2	14.2	-2.5	0.0

Эдийн засгийн ойрын ирээдүйн төлөв

Хэрэглэгчдийн эдийн засгийн ойрын ирээдүйн талаарх хүлээлт өмнөх улирлаас өссөн байна. Хэрэглэгчдийн 15.2 хувь нь ойрын ирээдүйд бизнесийн нөхцөл “сайн” байна гэж хариулсан нь өмнөх улирлаас 3.8 пунктээр өндөр, 19.5 хувь нь бизнесийн нөхцөл “муу” байна хариулсан нь өмнөх улирлаас 8.6 пунктээр доогуур байна. Харин ажил эрхлэлтийн нөхцөл байдал тодорхойгүй байна. Хэрэглэгчдийн

24.3 хувь нь ажлын олдоц сайжирна гэж үзсэн нь 3.8 пунктээр өндөр байгаа бол 17.8 хувь нь муудна гэж үзсэн нь 1.9 пунктээр өндөр байна. Орлогын ирээдүйн хүлээлт өссөн байна. 24.7 хувь нь орлого өснө гэж үзсэн нь 4.6 пунктээр өссөн байгаа бол, 14.2 хувь нь орлого буурна гэж үзсэн нь өмнөх улирлаас өөрчлөгдөөгүй байна.


Хэрэглэгчийн итгэл ба эдийн засгийн өсөлт

Хэрэглэгчийн итгэлийн индексийг олон улс орнууд үнэлж мэдээлдэг бөгөөд тухайн орны эдийн засгийн төлөв байдлыг сайн харуулж чаддаг гэж үздэг. Монгол Улсад ч ХИИ-ийг улирлаар үнэлж эхэлснээс хойшхи динамикийг харвал эдийн засгийн өсөлттэй ойрхон хамаа-

ралтай байна. ХИИ-ийн индекс хэвийн буюу 100 ба түүнээс дээш утгатай улирлуудад эдийн засаг дунджаар 6.1 хувийн өсөлттэй байсан бол ХИИ 100-гаас бага утгатай улирлуудад эдийн засаг 2.6 хувийн өсөлттэй байна.

Хэрэглэгчийн итгэл ба эдийн засгийн өсөлт

Хэрэглэгчийн итгэлийн индекс эдийн засгийн өсөлттэй ойрхон хамааралтай байна



Эх үүсвэр: ҮСХ-ны 1212.mn мэдээллийн сайт. Тайлбар: Эдийн засгийн өсөлтийн мэдээллийг ҮСХ-ны цахим хуудаснаас авсан.



2024 оны 1-р улиралд хэрэглэгчдийн эдийн засгийн өнөөгийн нөхцөл байдлын үнэлэмж өсөхөд бизнесийн нөхцөлийн талаарх үнэлэмж

өссөн нь нөлөөлжээ. Ойрын ирээдүйд бизнесийн нөхцөл, орлого өснө гэсэн хүлээлт байгаа ч ажлын олдоц тодорхойгүй байна.

Инфляцын хүлээлт

Ирэх нэг жилийн хугацаанд үнийн түвшин өснө гэсэн хүлээлттэй иргэдийн эзлэх хувь 76 байна. Хэрэглэгчид инфляцын түвшинг ирэх нэг жилийн хугацаанд 10.6 хувь байна гэсэн хүлээлттэй байна.


Хүлээгдэж буй инфляцын түвшинг өмнөх жилийн үзүүлэлттэй харьцуулахад 1 пунктээр өсжээ. Эндээс үзвэл иргэдийн дийлэнх хувь нь үнийн түвшин өснө гэж үзэж байгаа ба хүлээгдэж буй инфляцын түвшин өсөж байна. Энэ улиралд инфляцын талаарх тодорхой бус байдал өссөн. Өмнөх улиралд 7 хувь нь ирэх нэг

жилийн хугацаанд инфляцын өөрчлөлтийг мэдэхгүй гэж хариулсан бол энэ улиралд 9 болж өсжээ.

Хөдөө амьдардаг хэрэглэгчдийн ирэх нэг жилийн хугацааны үнийн түвшний хүлээлт Улаанбаатар хотод амьдардаг хэрэглэгчдээс өндөр байна. Хөдөөд жилийн хүлээгдэж буй инфляц 11.6 хувь байгаа бол хотод 10.1 хувь байна. Хөдөө болон хотод хүлээгдэж буй инфляцын зөрүү өмнөх улиралд 0.7 пункт байсан бол энэ улиралд 1.5 болжээ. Харин өмнөх оны мөн үед энэ зөрүү 0.5 байв.

Үнийн хүлээлт, ирэх нэг жилийн хугацаанд

Ирэх нэг жилийн хугацааны инфляцын хүлээлт 10.6% (Хөдөө-11.6%, Хот-10.1%) байгаа нь өмнөх оны мөн үеэс 1 пунктээр өндөр байна.



Эх сурвалж: ҮСХ-ны 1212.mn мэдээллийн сайт

